



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 29 (410)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Байнгын төлөөлөгч томилох тухай*
- *Хөтөлбөр батлах тухай*
- *Журам батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2005 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны наймдугаар сарын 7

№29 (410)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

882.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 24	634
883.	Цэндийн Моломд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай	Дугаар 26	634
884.	Авирмэдийн Биньезд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 27	634
885.	Жамъяангийн Батдоржид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 28	635
886.	Гүнсэнжавын Чулуунбаатарт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 29	635
887.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 30	635

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

888.	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 130	637
889.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 135	637
890.	Байнгын төлөөлөгч томилох тухай	Дугаар 137	638
891.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 138	638
892.	Журам батлах тухай	Дугаар 139	642
893.	Байнгын төлөөлөгч томилох тухай	Дугаар 140	644

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 7 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Боловсрол, эрүүл мэнд, төр захиргааны ажиллаж байгаа Архангай, Сүхбаатар аймгийн дор байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

- | | |
|--|---|
| 1. Тооногаваагийн Гомбосүрэн- Сүхбаатар аймгийн Онгон сумын өндөр настан, ахмад багш | 3. Дашнямын Рина- Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийг дэмжих нэгжийн ажилтан |
| 2. Лхамжавын Нанзад- Сүхбаатар аймгийн Асгат сумын хүн эмнэлгийн салбарын эрхлэгч | 4. Мажигийн Цэрэндорж- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын өндөр настан, ахмад багш |

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

- | | |
|--|---|
| 1. Уртнасангийн Батчулуун-Сүхбаатар аймгийн Асгат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга | 4. Дэжинцоогийн Сүхбаатар - Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл |
| 2. Хайдавын Жавзмаа- Сүхбаатар аймгийн Онгон сумын 10 жилийн дунд сургуулийн багш | |
| 3. Мичиджамбаагийн Ооёо- Сүхбаатар аймгийн Асгат сумын "Их-Уул" багийн Засаг дарга | |

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н. ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 7 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Цэндийн Моломд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Төрийн болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж санхүү, даатгал, банкны системийг боловсронгуй болгож бэхжүүлэх, эдийн засгийн удирдлага, хяналт шалгалтын тогтолцоог шинэчлэх, гадаад харилцааг өргөжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж "Монголын үндэсний даатгал" ХХК-ийн зөвлөх

Цэндийн Моломд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н. ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 7 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Авирмэдийн Биньээд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургууль болон Биньээд Монгол Улсын гавьяат багш цол боловсролын байгууллагад багш, мэргэжилтнээр олон жил үр бүтээлтэй ажиллаж өсвөр үеийг сурган хүмүүжүүлэх, бага ангийн багш нарын мэргэшил, үр чадвар, сургалтын чанарыг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Увс аймгийн Боловсрол, соёлын газрын арга зүйч Авирмэдийн хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н. ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

Дугаар 28

2005 оны 7 дугаар сарын 26–ны өдөр

Улаанбаатар хот

Жамъяангийн Батдоржид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж эмчилгээний шинэлэг аргуудыг эмнэлгийн практикт нэвтрүүлэн, хөдөөгийн хөдөлмөрчдөд мэс заслын нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс

заслын зөвлөх эмч Жамъяангийн Батдоржид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

Дугаар 29

2005 оны 7 дугаар сарын 26–ны өдөр

Улаанбаатар хот

Гүнсэнжавын Чулуунбаатарт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж монгол ардын, зохиолын дуунууд дуулж, хөгжимт драм, дуулалт жүжгийн гол, туслах дүр бүтээж, тэдгээрийг чадварлаг найруулан тавьж, хөдөөгийн хөдөлмөрчдөд урлаг, соёлоор үйлчлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж Увс аймгийн Хөгжимт драмын театрын найруулагч Гүнсэнжавын Чулуунбаатарт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

Дугаар 30

2005 оны 7 дугаар сарын 26–ны өдөр

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, тээвэр, холбоо, хөдөө аж ахуй, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон

жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Пялтганы Батчулуун- Увс аймгийн Ховд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

3. Цэрэнбадамын Пүрэв- Увс аймгийн Давст сумын малчин

2. Пэрэнлэйн Бямбажав- Увс аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны тэргүүн

“АЛТАН ГАДАС” ОДОНГООР:

1. Жамбалын Балхаажав- Увс аймгийн Улаангом сумын ахлах 1 дүгээр сургуулийн багш

5. Даржаагийн Батчулуун- Увс аймгийн Түргэн сумын өндөр настан, малчин

2. Цогоогийн Басанжав- Увс аймгийн Хяргас сумын хүн эмнэлгийн эрхлэгч, их эмч

6. Ишийн Буйдаа - Увс аймгийн Тээвэр зохицуулалтын албаны дарга

3. Зөөлөнгийн Баттөмөр- Увс аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн

7. Лодойн Гагийнаа- Увс аймгийн Цагаанхайрхан сумын хүн эмнэлгийн салбарын эрхлэгч

4. Баатарын Батчулуун- Увс аймгийн Улаангом сумын ахлах 2 дугаар сургуулийн багш

8. Дорлигжавын Долгор- Увс аймгийн Улаангом сумын “Бэл булаг” компанийн менежер

9. Нямаагийн Доржсүрэн- Увс аймгийн Улаангом сум дахь хэвлэлийн "Боршоон ундраа" компанийн хэвлэгч

10. Гаадангийн Дүүдэй- Увс аймгийн Улаангом сумын ахлах 2 дугаар сургуулийн бага ангийн багш

11. Үмээгийн Дээмээ- Увс аймгийн Тариалан сумын ахлах сургуулийн багш

12. Түнжингийн Лхагвасүрэн- Увс аймгийн хүнсний үйлдвэрлэлийн "Увс- Хүнс" ХК-ийн захирал

13. Дашийн Лхамаа- Увс аймаг дахь нефть хангамжийн баазын нягтлан бодогч

14. Лодонгийн Моломдагва- Увс аймгийн Улаангом сумын Засаг дарга

15. Сэржээгийн Мээлэй- ИНЕГ-ын харъяа Увс аймаг дахь Нисэх буудлын санхүүч

16. Батын Мядаг- Увс аймгийн Улаангом сумын ахлах 2 дугаар сургуулийн сургалтын менежер

17. Пагвагийн Намсрай- Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн захирал

18. Жавын Нанзад- Увс аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн ажилтан

19. Гелгений Онигоо- Увс аймгийн Тариалан сумын өндөр настан, ахмад тээвэрчин

20. Шавирангийн Орших- Увс аймгийн Түргэн сумын өндөр настан, төр, захиргааны байгууллагын ахмад ажилтан

21. Цагаачийн Отгонбаатар- Нийслэлийн үйлдвэрлэл үйлчилгээний "Таван богд трейд" ХХК-ийн ерөнхий захирал

22. Банздайн Оюунбат- Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

23. Дашийн Сайнхүү- Увс аймгийн Улаангом хотын Захирагчийн ажлын албаны ажилтан

24. Хонгорын Сүрэнжав- Увс аймгийн Мэргэжлийн хангалтын газрын улсын байцаагч

25. Дэмбэнгийн Сэр-Од- Увс аймгийн Зүүнхангай сумын холбооны салбарын эрхлэгч

26. Лхагваагийн Тогоо- Увс аймгийн Засаг дарга

27. Чулууны Цэвээн- Увс аймгийн Завхан сумын малчин

28. Хуушааны Цэдэв- Увс аймгийн Хяргас сумын малчин

29. Доржийн Цэдэнбал- Увс аймгийн Өмнөговь сумын өндөр настан, төр, захиргааны байгууллагын ахмад ажилтан

30. Аюурзанын Цэцэн- Увс аймгийн Өмнөговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажилтан

31. Раднаагийн Ядамсүрэн- Увс аймгийн Татварын хэлтсийн тасгийн дарга

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Ренчинсамбуугийн Алтанцэцэг-Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч

2. Цэрэндоржийн Баяндэлгэр- Увс аймгийн Өндөрхаан сумын нийгмийн халамжийн байцаагч

3. Гомбосүрэнгийн Бэгзжав- Увс аймгийн Давст сумын өндөр настан, намын ахмад ажилтан

4. Пэлжээгийн Ганбаатар- МАХН-ын Увс аймаг дахь хорооны дэд дарга

5. Ядамсүрэнгийн Ганбат-Нийслэлийн үйлдвэрлэл үйлчилгээний "Таван богд трейд" ХХК-ийн харъяа "Улаанбаатар принт" ХХК-ийн инженер

6. Цэндийн Дансран- Увс аймгийн Өмнөговь сумын малчин

7. Банздайн Дүүдэмбээ- Увс аймгийн Зүүнговь сумын татварын улсын байцаагч

8. Хорхойн Катав- Увс аймгийн Тариалан сумын "Хартарвагатай" компанийн ерөнхий нягтлан бодогч

9. Батбаярын Лхамхүү- Увс аймгийн Түргэн сумын дунд сургуулийн нярав

10. Сампилийн Магсаржав- Увс аймгийн Түргэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

11. Мишкагийн Мөнхтөр- Увс аймгийн Улаангом сумын "Чандмань-Увс" ХК-ийн слесарь

12. Бадрахын Мянгар- Увс аймгийн Завхан сумын малчин

13. Цэрэнгийн Нарантуяа- Увс аймгийн Хяргас сумын 8 жилийн дунд сургуулийн багш

14. Цэрэнгийн Отгон- Увс аймгийн Түргэн сумын дунд сургуулийн нийгмийн ажилтан



15. Чойсүрэнгийн Оюун- Увс аймгийн Хөгжимт драмын театрын оёдолчин

17. Дэчингийн Тэгшжаргал - Хөдөлмөрийн дээд сургуулийн Увс аймаг дахь салбар сургуулийн дэд захирал

16. Бэлтээгийн Сэрчмаа - Увс аймгийн Давст сумын хүн эмнэлгийн салбарын бага эмч

18. Цээжавын Юүпэл- МАХН-ын Увс аймаг дахь хорооны бичиг хэргийн эрхлэгч

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Батаагийн Сүх-Очир- Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн тасгийн дарга, дэд хурандаа

3. Нониогийн Эрдэнэ- Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн тасгийн дарга, дэд хурандаа

2. Даржаагийн Энхтайван- Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн ахлах байцаагч, ахмад

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 6 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 130

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Иргэний бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар нэвтрэх үнэмлэхэд Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газартай байгуулсан холбогдох хэлэлцээрт заагдсан хил орчмын сумдын засаг дарга нар тус тус гарын үсэг зурна".

1. Засгийн газрын 1997 оны 109 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын үндэсний гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам"-ын 13 дугаар заалтын 2 дахь өгүүлбэрийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил нарт даалгасугай.

"Эдгээр баримт бичигт нийслэлд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга, хэлтсийн дарга; аймагт иргэний бүртгэл, мэдээллийн албаны дарга, түүний эзгүйд тухайн аймгийн Засаг даргын тамгын газрын дарга, хууль зүйн хэлтсийн дарга, Сэлэнгэ аймгийн Мандал сум, нийслэлийн Багахангай, Налайх, Багануур дүүрэгт сум, дүүргийн засаг дарга, тамгын газрын дарга; хил

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

Ч.УЛААН

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"9. "Мэдээлэл, харилцаа холбооны тэргүүний ажилтан" тэмдэг-Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга".

Засгийн газрын 1997 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн төрөл болон тэдгээрийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-ын 9 дүгээр заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ц.ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА**

С.БАЯРЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 137

Улаанбаатар хот

Байнгын төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг болон Дипломат албаны тухай хуулийн 16.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Раднаабазарын Алтангэрэлийг Монгол Улсаас ЮНЕСКО-гийн дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр томилсугай.

1. Монгол Улсаас ЮНЕСКО-гийн дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Цэндийн Батбуянг зүүлэн татсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

**ГАДААД ХЭРГИЙН
САЙД** **Ц.МӨНХ-ОРГИЛ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 138

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

3. Засгийн газрын 2005 оны 66 дугаар тогтоолын 17 дугаар хавсралтад "39. "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний зөвлөл-Монгол Улсын Шадар сайд" гэж нэмсүгэй.

1. "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт ёсоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

4. "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Монгол Улсын Шадар сайд, хөтөлбөрийн Үндэсний зөвлөлийн дарга Ч.Улаанд даалгасугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Н.Алтанхуягт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, Үйлдвэр, худалдааны сайд С.Батболд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД** **Ч.УЛААН**

**ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН САЙД** **Д.ТЭРБИШДАГВА**

Засгийн газрын 2005 оны 138 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"НЭГ СУУРИН-НЭГ БҮТЭЭГДЭХҮҮН" ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Засгийн газрын 2004-2008 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг өрнүүлж, чанар сайтай, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүнийг шинээр бий болгож гадаад, дотоодын зах зээлд гаргахыг дэмжихээр заасны дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд "Нэг сум-нэг

бүтээгдэхүүн", "Нэг тосгон-нэг бүтээгдэхүүн" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр тусгасныг үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

2. "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөн анх 1970-аад оны сүүлчээр Японы Ойта мужид үүсэж багагүй амжилт олжээ. Энэхүү туршлагыг зөвхөн Японд төдийгүй Өмнөд Солонгос, Хятад, Тайланд, Филиппин, Малайз зээг дэлхийн 60 гаруй оронд нэвтрүүлсний 30 орчимд нь амжилттай

хэрэгжиж тодорхой үр дүнд хүрч байгаа юм. Уг хөдөлгөөн нь улс бүрт өөр өөрийн онцлогтой нэвтэрч хэрэгжсэн байна. Манай улсын хувьд 2002 оноос эхлэн Баянхонгор аймагт ийм хөдөлгөөн өрнүүлж, үйл ажиллагаа явуулсан нь үр дүнд хүрэх боломжтойг харуулсан байна.

Манай улсад тухайн нэг бүтээгдэхүүнээрээ орон даяар алдаршиж нэрд гарсан газрууд олон бий. Тухайлбал: Булганы "Сайханы айраг", Өвөрхангайн "Уянгын гэр", Сүхбаатар аймгийн "Дарьганга хийцийн үнэт эдлэл", Хэнтийн "Галшарын адуу", Баянхонгорын "Шаргалжуутын рашаан-сувилал" зэрэг олон бүтээгдэхүүнийг нэрлэж болно.

3. Бүтээгдэхүүн гэдэгт материаллаг үйлдвэрлэлээс гадна аялал жуулчлал, ардын урлаг, уламжлалт эмнэлэг зэрэг үйлчилгээ байж болох бөгөөд тэдгээр нь тухайн орон нутаг, бүс, улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, ажлын байр шинээр бий болгосон байх шаардлагатай. Энэхүү хөтөлбөр нь иргэдийн үүсгэл санаачилгыг өрнүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, шинэ төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгож хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой бөгөөд Засгийн газраас баталсан бусад хөтөлбөрүүд болон гадаад орон, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдтэй нягт уялдаатайгаар хэрэгжих болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

4. Орон нутгийнхаа боломж, давуу талыг ашиглан оршин суугчдынхаа бахархал болохуйц чанар сайтай, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэж бүс нутаг, улсын хэмжээнд борлуулан улмаар экспортод гаргах, гадаад, дотоодын иргэдийн сэтгэл татам шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх замаар орон нутгаа сэргээн хөгжүүлэх, эдийн засгийн харьцангуй бие даасан мужлал, үйлдвэрлэл-нутаг дэвсгэрийн цогцолбор бий болж, төрөлжин хөгжихөд дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

5. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилт дэвшүүлж байна:

5.1. хөтөлбөрийн зорилго, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан ойлгуулах;

5.2. иргэдийн санал, санаачилгыг дэмжих;

5.3. хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

6.1. иргэдийн бүтээлч санал, санаачилгад тулгуурлах;

6.2. дэлхийн хэмжээнд сэтгэж, орон нутгийн түвшинд бүтээх;

6.3. хүний хүчин зүйлийг үнэлэх, чадавхийг сайжруулах;

6.4. маркетингийн зарчмуудыг хэрэгжүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

7. "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөтөлбөр нь дараахь үе шатаар хэрэгжинэ:

7.1. Нэгдүгээр үе шат-2005-2008 он: Хөтөлбөрийг сурталчлах, мэргэжил арга зүйн удирдлага, мэдээллээр хангах, үзэсгэлэн зохион байгуулах, туршлага солилцох, шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах үйл ажиллагаа зонхилон хэрэгжинэ.

7.2. Хоёрдугаар үе шат-2009-2012 он: Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх, татвар, зээл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих, борлуулалтын сүлжээ бий болгох, сурталчлах, зарим бүтээгдэхүүнийг экспортод гаргах зэрэг үйл ажиллагаа явагдана.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

8. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь үйл ажиллагааг явуулна:

8.1. Хөтөлбөрийн зорилго, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан ойлгуулах зорилтын хүрээнд:

8.1.1. "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөтөлбөрийн зорилго, ач холбогдол болон гадаад, дотоодын туршлага, сургамжийн талаар радио, телевизээр нэвтрүүлэг хийх;

8.1.2. сонин, хэвлэлд "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" булан нээж, иргэдийн санаа бодол болон энэ чиглэлээр хийж байгаа ажлыг нийтэлж нийтийн хүртээл болгох;

8.1.3. орон нутгийн онцлог, давуу талаа ашиглан ямар төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэх боломжийн талаар төрөлжсөн ярилцлага зохион байгуулах;

8.1.4. шилдэг бүтээгдэхүүний үзэсгэлэн-худалдааг жил бүр сум, аймаг, бүс, улсын түвшинд үе шаттайгаар зохион байгуулах;

8.1.5. шалгуур хангасан бүтээгдэхүүн, илчилгээнд тусгай гэрчилгээ олгож, улс даяар ярлах;

8.1.6. улсын хэмжээнд жил бүр онцгой ач элбэгдөл бүхий 10-аас цөөнгүй бүтээгдэхүүн, илчилгээг шалгаруулж урамшуулах;

8.1.7. "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" загвар эсвэл боловсруулж сурталчлах;

8.1.8. улсын хэмжээнд шалгарсан үтээгдэхүүний зар сурталчилгааг олон нийтийн эдээллийн хэрэгслээр явуулах.

8.2. Иргэдийн санал, санаачилгыг дэмжих орилтын хүрээнд:

8.2.1. тухайн орон нутагт урьд нь хийж айгаад орхигдсон бүтээгдэхүүнийг сэргээн өгжүүлэх боломжийг судлах;

8.2.2. шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон борлуулах, зах зээлээ өргөжүүлэх сүлжээ бий болгоход туслалцаа зүүлэх;

8.2.3. аймаг бүрт эхний ээлжинд нэг үтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үгсүүдэд нь загвар болгон хөгжүүлэх;

8.2.4. импорт орлох буюу экспортод гаргах зорилцоотой бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг гэмэгдүүлэх, үйлчилгээг өргөтгөх чиглэлээр төнгөлөлттэй зээл олгох;

8.2.5. одоо үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулж, эрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

8.2.6. орон нутгийнхаа онцлог, түүхий эдийн чөөц, уламжлал, давуу талаа ашиглан олон нийтийн гаашаалд нийцсэн шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх;

8.2.7. Засгийн газраас тогтоосон тэргүүлэх чиглэлд хамаарах үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг эхний 3 жилийн хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлэх;

8.2.8. "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа төслийг "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөрөнгө оруулалт, хөгжлийн сан"-гаас болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр дэмжлэг үзүүлэх.

8.3. Хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

8.3.1. уг хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн улс, орны туршлагыг газар дээр нь очиж судлах, сургалтад оролцох;

8.3.2. "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг санаачлагчид болон энэ чиглэлээр мэргэшсэн гадаад, дотоодын хүмүүсийг урьж лекц уншуулах, туршлагыг нь түгээх;

8.3.3. "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг бүтээлчээр хэрэгжүүлж байгаа зарим улс, мужийн туршлагыг өөрийн орны тодорхой бүс нутагт туршиж нэвтрүүлэх;

8.3.4. "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газраас баталсан бусад хөтөлбөр болон гадаад орон, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөлтэй уялдуулах;

8.3.5. хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйлсэд эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагыг өргөнөөр оролцуулах;

8.3.6. шинэ бүтээгдэхүүнийг бусад суурин, аймаг, бүс нутагт борлуулах, шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэхэд аймаг, сум дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

8.3.7. бүс нутаг, улсын хэмжээнд шалгарсан брэндийн бүтээгдэхүүнийг экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх.

Зургаа. Бүтээгдэхүүн, үйлчилгээний шалгуур үзүүлэлт

9. Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь дараахь шалгуур үзүүлэлтийг хангасан байна:

9.1. бүтээгдэхүүн нь тухайн орон нутгийн түүхий эдэд тулгуурласан байх;

9.2. онцлог үйлчилгээ нь бусдаас ялгарах давуу талтай байх;

9.3. шинэ болон шинэчилсэн бүтээгдэхүүн нь стандартаар баталгаажсан, чанарын тэмдэг, бүтээгдэхүүний тэмдэг /logo/-тэй байх;

9.4. бүтээгдэхүүн, үйлчилгээ нь тухайн сумаас гадна бусад сум аймаг, бүсийн хэмжээнд борлогдсон байдал;

9.5. тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлснээр орон нутагт ажлын байр нэмэгдсэн байх;

9.6. орон нутгийн төсөвт татвар төлж тодорхой хэмжээний орлого оруулсан байх;

9.7. бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ нь байгаль орчинд халгүй байх.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

10. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

10.1. Хөтөлбөрийг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл нь хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах бөгөөд бус нутаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд тухайн шатны салбар зөвлөлүүд тус тус ажиллана.

10.2. Хөтөлбөрийн Үндэсний зөвлөлийг Монгол Улсын Шадар сайд ахлах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд Засгийн газрын зарим гишүүд, дэд сайд, яамдын холбогдох албан тушаалтнууд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл орсон байна.

10.3. Салбар зөвлөлийг тухайн шатны Засаг дарга ахлаж, гишүүдэд орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл тус тус орсон байна.

10.4. Хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Үндэсний зөвлөл; орон нутгийн түвшинд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг тухайн шатны Засаг дарга батална.

10.5. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг улсын хэмжээнд Үндэсний зөвлөл; салбарын хүрээнд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; орон нутгийн түвшинд салбар зөвлөл, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар хангаж ажиллана.

10.6. Сум, суурин бүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тухайн оны үр дүнг оны эцэст шалгуур үзүүлэлтийн дагуу сум, суурингийн Засаг даргын Тамгын газар дүгнэж аймаг, нийслэлийн салбар зөвлөлд тайлагнана. Сум, суурингийн тайланг

аймаг, нийслэлийн салбар зөвлөл нэгтгэж, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчийн Хуралд танилцуулж Хөтөлбөрийн үндэсний зөвлөлд оны эхний 2 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ.

11. Хөтөлбөрийн санхүүжилт

11.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

11.1.1. иргэдийн өөрийн хөрөнгө;

11.1.2. аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө;

11.1.3. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

11.1.4. хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, техникийн болон буцалтгүй тусламж, хандивын хөрөнгө;

11.1.5. бусад.

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

12. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр хэмжинэ:

12.1. хөтөлбөрийн хүрээнд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, тоо хэмжээ, түүний өсөлт;

12.1.2. дотоодод борлуулсан бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээ, борлуулсан орлогын өсөлт;

12.1.3. экспортод гаргасан бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээ, борлуулсан орлогын өсөлт;

12.1.4. шинээр бий болсон ажлын байрны тоо, өсөлт.

13. Тухайн жил хөтөлбөрийн хүрээнд хүрэх шалгуур үзүүлэлтийг бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, түүний өсөлт, бий болгосон ажлын байр, борлуулалтын хэмжээ, сурталчилгааны нэр төрөл, тоо хэмжээ зэргээр оны эхэнд Үндэсний зөвлөл; сум, суурин бүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тухайн оны шалгуур үзүүлэлтийг аймгийн салбар зөвлөл тус тус батална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Тариалангийн тухай хуулийн 4.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Буудай" санг "Тариалан эрхлэлтийг дэмжих сан" болгон зохион байгуулж, аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулсугай.

2. "Буудай" сан болон тус сангийн Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Хөтөл, Сүхбаатар хот дахь Сэлэнгэ, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Хархорин салбаруудыг үндсэн болон эргэлтийн хөрөнгө, өр авлагын хамт "Тариалан эрхлэлтийг дэмжих сан"-д тус тус шилжүүлсүгэй.

3. "Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам"-ыг хэвсрэлт ёсоор баталсугай.

4. "Тариалан эрхлэлтийг дэмжих сан"-гийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, Сангийн сайд Н.Алтанхуяг нарт даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1999 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 37 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	Ц.ЭЛБЭГДОРЖ
САНГИЙН САЙД	Н.АЛТАНХУЯГ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД	Д.ТЭРБИШДАГВА

Засгийн газрын 2005 оны 139 дүгээр тогтоолын хэвсрэлт

ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГ БҮРДҮҮЛЭХ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Тариалан эрхлэлтийг дэмжих сан /цаашид "сан" гэх/-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

2. Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй байна.

3. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зориулалтын дагуу захиран зарцуулах, тайлагнах, санхүүжилтийн байдал болон сангийн бусад үйл ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуйн яам хяналт тавина.

4. Тариалан эрхлэлтийг дэмжих сан, түүний салбар нь Төрийн санд тусгай данстай байх бөгөөд тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Сангийн зохион байгуулалт

5. Сангийн удирдах зөвлөл /цаашид "удирдах зөвлөл" гэх/ нь 7-9 гишүүнтэй байх бөгөөд Сангийн яамнаас төлөөлөл оролцсон байна. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх захирлыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд батлах бөгөөд удирдах зөвлөлийн дарга нь Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд байна.

6. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд 1-ээс доошгүй хуралдана. Удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

7. Удирдах зөвлөлийн хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлж, дарга, сангийн гүйцэтгэх захирал нар гарын үсэг зурна. Удирдах зөвлөлөөр хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, шаардлагатай гэж үзвэл тогтоол гаргана. Удирдах зөвлөлийн тогтоолд дарга, сангийн гүйцэтгэх захирал гарын үсэг зурна.

8. Удирдах зөвлөл дор дурдсан бүрэн эрхтэй байна:

8.1. сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, сангийн хөрөнгийг өсгөх талаар гарсан санал, санаачилгыг дэмжих;

8.2. сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

8.3. сангийн хөрөнгөөс эргэн төлөх нөхцөлөөр олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт тавьж, зээлийг хугацаанд нь төлүүлэх ажлыг зохион байгуулах;

8.4. сангийн гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэн, шагнал урамшлын асуудлыг шийдвэрлэх, сангийн үйл ажиллагаанд хяналт тавих;

8.5. сангийн төсөв, орлого, зарлагын төлөвлөгөө, түүний тайлан мэдээг хэлэлцэж, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх.

9. Сангийн орон нутаг дахь салбарын эрхлэгчийг томилж, тухайн салбарын орон тоо, жилийн орлого, зарлагын төсөв, төлөвлөгөөг Удирдах зөвлөлийн саналыг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн сайд батална.

10. Сангийн гүйцэтгэх захирал энэхүү журам, Удирдах зөвлөлийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд заасан эрх хэмжээний дотор сангийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулна.

11. Сангийн гүйцэтгэх захирал дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ:

11.1. энэхүү журам болон холбогдох хууль тогтоомж, Удирдах зөвлөлийн шийдвэр, тухайн жилийн үйл ажиллагааны чиглэл, бизнес төлөвлөгөө, Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

11.2. сангийн хөрөнгийг Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу захиран зарцуулах;

11.3. сантай холбогдон үүссэн өр, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах;

11.4. тариаланчид, гурилын үйлдвэрүүдийн буудайн эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор үрийн болон таваарын улаан буудай, таримлын үрийн нөөц бүрдүүлэх, борлуулах;

11.5. Удирдах зөвлөлийн даргын зөвшөөрснөөр арилжааны банк, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ байгуулах, дүгнэх;

11.6. хандивлагч орон, олон улсын байгууллагатай байгуулсан гэрээ, хэлэлцээрт сангийн хөрөнгийг арилжааны банкинд байрлуулахаар тусгайлан заасан бол тухайн сангийн чөлөөт хөрөнгийг банкинд оновчтой байршуулж, эх үүсвэрийг нэмэгдүүлэх;

11.7. сангийн үйл ажиллагааны жилийн тайланг Удирдах зөвлөл, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөлийн хуралд танилцуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлан, балансыг гаргах, аудитын дүгнэлт гаргуулах, тайлагнах.

12. Сангийн орон нутаг дахь салбарын өдөр тутмын үйл ажиллагааг салбарын эрхлэгч гүйцэтгэх өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллана.

Гурав. Сангийн хөрөнгийн төлөвлөлт, эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалт

13. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх эх үүсвэр:

13.1. улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

13.2. тариалангийн салбарт гадаад орон, олон улсын байгууллагаас олгосон зээл, буцалтгүй тусламж;

13.3. сангийн хөрөнгийг банкинд хадгалуулсны хүү;

13.4. иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, тусламж;

13.5. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

14. Сангийн хөрөнгийг дараахь зориулалтаар зарцуулна:

14.1. усалгаатай тариаланг хөгжүүлэх, усалтын систем байгуулах, сэргээн засварлах;

14.2. тариалангийн газрын хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх;

14.3. таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлэх;

14.4. хөдөө аж ахуйн техник, технологийн шинэчлэлт хийх;

14.5. тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчээс стандартын шаардлага хангасан үрийн болон хүнсний борлогдоогүй үлдсэн буудайг худалдан авах;

14.6. сангийн үндсэн хөрөнгөд засвар, үйлчилгээ хийх.

15. Хандивлагч орон, олон улсын байгууллагатай байгуулсан гэрээ, хэлэлцээрт зориулалтыг нь тусгайлан заасан тохиолдолд олгосон зээл, буцалтгүй тусламжийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна.

Дөрөв. Сангийн үйл ажиллагаа

16. Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь мөнгөн сан байх бөгөөд улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна. Гадаадын зээл, тусламжийн бараа, бүтээгдэхүүнийг хүлээн авч хадгалах, хатааж, цэвэрлэх технологийн шаардлагыг ханган борлуулж, сан бүрдүүлнэ. Хүнс, хөдөө аж ахуйн яам Удирдах зөвлөлийн саналыг тусгах замаар сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг хянан боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад оруулан төлөвлөж тайлагнаана. Сангийн яам сангийн орлого, зарлагыг хянаж, жил бүрийн улсын төсвийн төлөвлөгөөнд тусгана.

17. "Тариалан эрхлэлтийг дэмжих сан"-гийн тухайн жилийн орлого, зарлагын төсөв, сангийн хагас жилийн болон жилийн эцсийн төсвийн тайланг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн Хүнс, хөдөө аж ахуйн сайд батална.

18. Сан нь Засгийн газрын шийдвэрийн дагуу хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа зарим хөтөлбөр, төслийн хөрөнгийг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвшөөрснөөр захиран зарцуулах, эргэн төвлөрүүлэх ажлыг зохицуулна.

19. Сангийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн

гуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр эцэглэнэ.

20. Санд худалдан авах болон борлуулах ийн болон таваарын буудай, таримал ургамлын ийн хэмжээ, үнийн доод хэмжээг зах зээлийн хайн жилийн ханшийг харгалзан Хүнс, хөдөө аж үйл сайд тогтооно.

21. Сан нь худалдан авсан үрийн болон ваарын буудай, таримлын үр, бараа материалыг дгалах зорилгоор бусад аж ахуйн нэгжийн уулах, цэвэрлэх, хатаах төхөөрөмжийг сонгон авч рээсээр ашиглаж болно.

22. Сангийн орон нутгийн салбар нь буудай олон таримлын үр хадгалах, цэвэрлэх, борлуулах дэд зйлшгүй шаардлагатай ажилчид, эргэжилтнийг түр хугацаагаар гэрээний үндсэн дээр авч ажиллуулж болно.

23. Сангийн хөрөнгөөр худалдан авсан үнсний буудайн борлоогүй үлдэгдлийг Засгийн эрэн шийдвэрийн дагуу экспортод гаргаж болно.

Тав. Сангийн хөрөнгийн зарцуулалтад өмч хяналт, тайлагналт

24. Сангийн орлого, зарлагын улирлын үндсэн тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдөр, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор тус тус гаргаж, Хүнс, хөдөө аж үйл яам, Сангийн яаманд тайлагнана.

25. Сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудитын үгнэлт гаргуулсан байна.

26. Сан нь төсвийн хөрөнгөөс гадна бусад өмч үүсвэрээс бүрдэж байгаа бол жилийн эцсийн

зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор өдөр тутмын хэвлэлд нийтлүүлж нийтэд мэдээлнэ.

Зургаа. Бусад зүйл

27. Сан нь дор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

27.1. Сангийн сайдын зөвшөөрөлгүйгээр гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгжээс зээл авах, хамтарсан үйл ажиллагаа эрхлэх;

27.2. сангийн хөрөнгийг бусдад барьцаалах, хөрөнгөөрөө бусад байгууллага, аж ахуйн нэгжид баталгаа гаргах;

27.3. санд хүлээн авсан буудайг зээлээр олгох, урьдчилгаа төлбөр хийгээгүй нөхцөлд буудайг борлуулах;

27.4. Сангийн сайдын зөвшөөрөлгүйгээр сангийн буудайг даатгалд хамруулах;

27.5. Сангийн хөрөнгөөр хандив өргөх, төрөл бүрийн арга хэмжээг ивээн тэтгэх, санхүүжүүлэх;

27.6. Худалдан авсан буудайн үнийг дотоодын зах зээлийн ханшид нөлөөлөхөөр хэт өсгөх, бууруулах.

28. Сангийн хөрөнгийг зориулалтаар бус зүй бусаар зарцуулсан эрх бүхий албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

29. "Тариалан эрхлэлтийг дэмжих сан"-г татан буулгасан тохиолдолд түүний өмч хөрөнгөтэй холбоотой асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 6 дугаар
арын 22-ны өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот

Байнгын төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар үйллийн 5 дахь хэсэг болон Дипломат албаны тухай уулийн 16.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсаас НҮБ-ын Женев дэх албар, олон улсын бусад байгууллагын дэргэд уугаа Байнгын төлөөлөгч Хасбазарын Бэхбатыг гүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Швейцарийн Холбооны улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

Данзанноровын Болдбаатарыг Монгол Улсаас НҮБ-ын Женев дэх салбар, олон улсын бусад байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ГАДААД ХЭРГИЙН
САЙД

Ц.МӨНХ-ОРГИЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.

"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар- 12,

Төрийн ордон

☎ 265958

Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын

Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 267497

Хэвлэлийн хуудас 1.5